

Ард Лайф

2020 оны онцлох үйл явдал

- 20 хувийн хөрөнгө оруулалтын өгөөж хуваарилав
- Хувийн тэтгэврийн хуулийн төслийг өргөн барих ажилд оролцов
- Харилцагчдын тоо 763 хувиар өсөв

Үйл ажиллагааны тайлан

2020 он Ард Санхүүгийн Нэгдэл ХК (Ард)-ийн хувьд бусад үйл ажиллагаа эрхлэн явуулж буй аж ахуйн нэгжүүдийн ижил хүнд цаг үе тохиосон хэдий ч бид цахим орчныг боломж мэт харж Ард Аппаараа дамжуулан бүхий л охин компаниуддаа өсөлтүүдийг авчирч чадсан нь өнгөрсөн оны шалгуур мэт даваа байлаа. Ард Лайф ХХК (Ард Лайф)-ийн хувьд ч тэр харилцагчдын тоо, хөрөнгө оруулалтын үнэлгээ, нийт тэтгэврийн хуримтлал гээд голлох үзүүлэлтүүд дээр урьд өмнө үзүүлж байгаагүй түүхэн өсөлтүүдийг үзүүлж чадсан жил өнгөрлөө.

Оны эхний улиралд багтаан Ард Лайф нь хөрөнгө оруулалтын өгөөжөөр өсөх нөхцөлтэй хуримтлалын данс үүсгэсэн харилцагч нартаа өмнөх жилийн хөрөнгө оруулалтын өгөөжийг тараан хуваарилдаг бол бид харилцагчдадаа жилийн 20 хувийн хөрөнгө оруулалтын өгөөжийг хуваарилсан амжилттай 2020 оныг эхлүүлэв.

2020 оны эхний хагаст Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд шинээр 5 гишүүн томилогдож, тэдгээр дунд хөрөнгийн болон даатгалын зах зээлд чамгүй туршлага хуримтлуулсан Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах, Ардын Хөрөнгө оруулалт хариуцсан захирал Э.Амарбаясгалан,

Ард Лайфын Гүйцэтгэх захирал Б.Гантулга, Нэксүс ББСБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Оюун-Эрдэнэ, ING Bank Монголиа-ийн төлөөлөгч Э.Сангаамаа нар багтав. Шинэ удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнтэйгээр хөрөнгийн удирдлагын оновчтой шийдвэрүүдийг гаргаж, Ард Лайфын хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц нь 2020 оны байдлаар 2.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 148 хувиар өсөв.

Ард Лайф нь цар тахлын үед ч тэр сургалтуудаа үргэлжлүүлж, албан байгууллага болон иргэдэд цахимаар мэдээллээ цаг алдалгүй хүргэж чадсанаар хамтран ажилладаг байгууллагын эгнээнд 34 албан байгууллага болон тэдгээрийн ажиллагсад багтаж байна. Ард Аппыг ашиглан иргэдэд тэтгэврийн хуримтлал нээх боломжийг бий болгож өгснөөр сайн дурын үндсэн дээр хуримтлал үүсгэж буй харилцагчдын тоо 2020 оны эцэст 10,447 болж, жилийн дотор 763 хувиар өссөн нь Ард Лайфын хувьд цахим орчныг оновчтой ашиглаж, иргэддээ хүрч ажилласан амжилтыг илэрхийлж байна. Харилцагчдын тоо өссөнөөр Ард Лайф дахь тэтгэврийн хуримтлалын дүн ч өмнөх жилийн эцсээс 100 хувиар өсөж, 3.4 тэрбум төгрөгт хүрэв.

Мөн Ард Лайф нь нийгмийн ажилд идэвхтэй оролцдог ба 2020 онд чухалчилж оролцож, хувь нэмрээ оруулсан томоохон ажил нь яах аргагүй - тэтгэврийн тогтолцооны шинэчлэл хийх ажлын хэсэгт багтан, ард иргэдэд хувийн тэтгэврийн талаарх мэдлэг боловсрол олгох, хувийн тэтгэврийн хуулийн төсөлд гаднын туршлага, Монгол Улсын зах зээлд тохиромжтой тэтгэврийн хуримтлалын бүтээгдэхүүний нөхцөлүүдийг тусгаж өгөх байв. Энэхүү ажлын хүрээнд бид Хөрөнгө Оруулагч Үндэстэн аяныг зохион байгуулж, Монгол Улсын 14 аймгуудыг тойрч, ард иргэдэд тэтгэврийн хуримтлалын ач холбогдол, түүний ирээдүйн үр ашиг, хойч үед өвлөгдөх хөрөнгийн талаар мэдлэг олгохын сацуу санхүүгийн боловсролыг түгээж ажилласан. Энэ мэт нийгэмд хүргэдэг сургалт,

танилцуулгууд маань үр дүнгээ үзүүлж, нийгэм тэтгэврийн тогтолцоог шинэчлэх ажлыг хойч үед эерэг нөлөө авчрах томоохон өөрчлөлт хэмээн чухалчилж үздэг болсон билээ. Хувийн тэтгэврийн хуулийн төслийн хүрээнд бид Улсын Их Хурал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн Хөгжлийн Банкны төслүүд дээр тус тус ажиллаж, хуулийн төслийг боловсруулахад идэвхтэй хувь нэмрээ оруулж чадсан билээ. Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын нийт иргэдийн эрх ашигт нийцсэн, ирээдүйг нь баталгаажуулсан, урт удаан, эрүүл энх, жаргалтай амьдрах итгэлийг өгсөн, Монгол хүн эх нутгийнхаа баялагт эзэн суух үүд хаалгыг нээх түүхэн өөрчлөлт авчирна гэдэгт бид итгэлтэй байна.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

